



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn


2019.10.15 № 05/8572
танай 2019.10.02 ны № 03/3720, 3716, 3717

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын олон улсын зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Энхбаатарын Ариунцэцэг, салбарын суурь судалгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Бямба-Очирын Мөнхбаяр, мөн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн үйлдвэрлэлийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Даваагийн Баярмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын салбарын сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээчээр томилогдохоор нэр дэвшсэн Алтангэрэлийн Лхамсэржид, Барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээчээр томилогдохоор нэр дэвшсэн Агвааны Энхтүвшин, салбарын ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээчээр томилогдохоор нэр дэвшсэн Эрдэнэбатын Батболд, Барилга, хот байгуулалтын сайдын хэвлэлийн төлөөлөгчөөр томилогдохоор нэр дэвшсэн Билимийн Нурбота нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэх, түүнчлэн хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т зааснаар тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргах үүргийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0014693